



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/433

Ховд

Төсөл сонгон шалгаруулалт
зохион байгуулах тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2017 оны 347 дугаар тогтоолоор баталсан Ховд хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сум, Цамбагарав баг, Л.Лааганы 2 дугаар гудамжны 206 тоотод байрлах 2659 метр квадрат газарт газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж явуулсугай.

2. Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг хавсралтаар баталсугай.


3. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох материалыг хуулийн дагуу бүрдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
08 дугаар сарын 19-ний өдрийн
А/433 дугаар захирамжийн хавсралт




ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Байршил	Эзэмших хугацаа	Хэмжээ /метр квадрат/	Зориулалт
1.	Жаргалант сум, Цамбагарав баг, Л.Лааганы 2 дугаар гудамжны 206 тоот	15	2659	Албан хэрэгцээний

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны
08 дугаар сарын 19-ний өдрийн
А/433 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЯВУУЛАХ ТУХАЙ

Нэг: Төсөл сонгон шалгаруулах тухай үндсэн мэдээлэл

1.1 Газрын тухай хууль, Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу дараах газрыг төсөл сонгон шалгаруулалтын журмаар шийдвэрлэх.

Хоёр. Төсөл сонгон шалгаруулалтад оролцох сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дор дурдсан ерөнхий нөхцөл, шаардлага хангасан байвал зохино.

2.1 Төсөл сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлсэн этгээд дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1 Хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай байх;

2.1.2 Мэргэжлийн ажиллах хүчний болон техник технологи, тоног төхөөрөмжийн чадавх, нөөцтэй байх;

2.1.3 Төсөл нь зарласан нөхцөл шаардлага, стандартыг хангасан байх;

2.1.4 Төслөө зарласан хугацаанд ирүүлсэн байх;

2.1.5 Шаардлагатай тохиолдолд холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байх.

2.2 Төслийг дор дурдсан шалгуур үзүүлэлтээр шалгаруулна.

2.2.1 Төсөл нь зард тусгасан шаардлага болон бүрдлийг хангасан эсэх;

2.2.2 Барилга, хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагад нийцсэн эсэх;

2.2.3 Төслийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500 стандартын дагуу боловсруулсан эсэх;

2.2.4 Төсөл нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулагдсан бизнес төлөвлөгөөтэй эсэх;

2.2.5 Төсөл нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын болон чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаж түүнд нийцсэн эсэх;

2.2.6 Төсөл хэрэгжсэнээр шинээр бий болох ажлын байрны тоо, хэмжээ;

2.2.7 Тухайн хот, тосгон, суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжилд ач холбогдолтой эсэх;

2.8 Улс, орон нутгийн төсөвт оруулах орлогын хэмжээ;

2.2.9 Тухайн газарт явуулах үйл ажиллагаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх;

2.3 Оролцогчид нь төслөө битүүмжилж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт өөрөө өгөх буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хүргүүлэх, хэрэв ийнхүү хүргэх боломжгүй бол зар мэдээнд заасан хугацаанд шуудангаар ирүүлж болно.

2.18 Оролцогч нь хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвар болон төсөл шалгаруулалтад ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцна.

2.19 Шалгарсан иргэн, аж ахуйн нэгж гэрээ байгуулснаас хойш нэг жил /365/ хоногийн дотор төслийн ажлаа эхлүүлээгүй тохиолдолд гэрээг үл маргах журмаар цуцална.

2.20 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан /12500төг/ хураамж төлнө.

2.21 Шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх болон төслийг ирүүлэх эцсийн хугацаа

Материалыг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 15:00 цаг /Улаанбаатарын цагаар/ хүртэл Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан байранд хүлээн авна.

Холбогдох мэдээллийг 70434018, 99038341, 88085865 утсаар лавлана уу.